

**АРВАЙХЭЭР СУМЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ ОН ДАМЖСАН
БОЛОН 2024 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮНГИЙН ТУХАЙ
ТӨСВИЙН ХЯНАЛТЫН СОНСГОЛ ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 04 дүгээр сарын 26

Арвайхээр сум

Арвайхээр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны он дамжсан болон 2024 оны төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн тухай төсвийн хяналтын сонсгол 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 10 цаг 15 минутад "Арвайхээр" хуралдааны танхимд эхлэв.

Сонсгол даргалагч Т.Чимэддорж нээж үг хэлэн, сонсголын дэг дарааллыг танилцуулав. Сонсголд Засаг дарга Б.Ганбат, санхүүгийн албаны дарга Ж.Ганзориг, Арвайхээр сумын тохижилт ОНӨААТҮГ-ын дарга Л.Сүх-өлзий, нягтлан бодогч Н.Нацагням, ХЗА-ын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Цэвэлмаа, нар оролцлоо.

Мөн тендер гүйцэтгэгч 13 байгууллага оролцохоос Хас гарьд ХХК, Их Өшгөг ХХК, Пүүлүүбумба ХХК, Прожект девелопмент тотал ХХК, Ти Си Пи ХХК-ууд оролцсонгүй. Сонсголд оролцогч 4, ажиглагч байхгүй, дуудагдаж ирсэн албан тушаалтан 6 оролцов.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Арвайхээр сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны он дамжсан болон 2024 оны төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн тухай төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах тухай

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Арвайхээр сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны он дамжсан болон 2024 оны төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн тухай төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах тухай

СОНССОН нь:

Т.Чимэддорж: (Сонсгол даргалагч) Сонсголын дарааллын дагуу 2024 оны ОНХС-ийн төсвийн зарцуулалт, явц гүйцэтгэлийн үр дүнгийн тухай сумын Засаг дарга Б.Ганбат танилцуулна.

Б.Ганбат: (Сумын Засаг дарга) Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Дуудагдаж ирсэн алба тушаалтнуудаас 3 хүн байхгүй байна. Орлогч дарга, ЗДТГ-ын дарга 2 эрүүл мэндийн шалтгаанаар хотод явж байгаа. ХЗА-ны ерөнхий менежер гадаад руу ажлаар явсан, 2024 оны ОНХС-ийн төсвийн зарцуулалт, явц гүйцэтгэлийн үр дүнгийн тухай танилцуулав.

Т.Чимэддорж: (Сонсгол даргалагч) Дарааллын дагуу орон нутгийн хөгжлийн санд хийсэн аудитын дүгнэлтийг Санхүүгийн албаны дарга Ж.Ганзориг танилцуулна.

Ж.Ганзориг: (Санхүүгийн албаны дарга) Сонсголд хүрэлцэн ирсэн та бүхний амар амгаланг айлтгая. Төсвийн тухай хууль болон холбогдох Аудитын тухай хуульд зааснаар энэ жил 2 сард нийслэлийн аудит хийгдсэн. Гүйцэтгэлийн аудит 5 сард хийгдэхээр төлөвлөгөөтэй байгаа. Орон нутгийн хөгжлийн санд хийсэн аудитын дүгнэлтийг танилцуулав. Дүгнэлтийг тэмдэглэлд хавсаргав

Т.Чимэддорж: (Сонсгол даргалагч) 2023 оноос 2024 он дамжсан 2024 оны ОНХС-ийн төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн тухай мэдээллүүдийг танилцууллаа. Мөн ОНХС-д хийгдсэн аудитын дүгнэлтийг Санхүүгийн албанаас танилцууллаа.

Сонсголын ирцийг танилцуулав.

Оролцогч 9 бүртгүүлснээс 3, ажиглагч 7 бүртгүүлснээс хараахан ирж амжаагүй, ажил гүйцэтгэгч компаниудаас 10 оролцохоос 3 оролцож байна. Дэгийн дагуу оролцогчид асуулт асуух, санал хэлэх эрхтэй хугацаа 10 минут хүртэлх байна. Оролцогчид дэгээ ыбаримтлаад, ОНХС-тай холбоотой асуудал, асуулт байвал холбогдох албан тушаалтнуудаас асууя. Асуулт асуух оролцогчид нэрсээ өгнө үү. П.Баярсайхан, Түмэнжаргал, Д.Сосорбурам

П.Баярсайхан: (3-р багийн иргэн) Өнөөдрийн сонсголд оролцож буй та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Худгуудыг цахимжуулах ажил хийгдсэн байгаа. Сүүлийн үед худгийн цахимжуулалт эвдрэх тохиолдолд их гарч байна. Өнгөрсөн жилийн гашуун туршлага бидэнд байгаа. 5 хоног тог тасарч цахим худгууд бүгд хөлдсөн. Тог тасарлаа гэхэд Арвайхээр сумын хэмжээнд усгүй болдог. Цахим худгууддаа тог баригч хийж болохгүй юу?

Э.Түмэнжаргал: (8-р багийн иргэн) Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Баярсайхан ахын асуулттай давхцаж байна. Усан санд хийгдсэн ажлууд дээр гэрээндээ баталгаат хугацаа нь хэдэн сар, жил байдаг вэ? Эвдэрсэн тохиолдолд тухайн компани хэдий хэр хугацаанд засаж янзлах вэ?

2 дугаарт “Эко нойл” хийгдэх явцад ИТХ-ын ажлын хороо хяналт шалгалт хийсэн. Тухайн ажлын хорооны дүгнэлттэй танилцмаар байна. Эко нойл хэр чанартай, үр бүтээмжтэй хийгдэж байгаа вэ? “Эко нойл”-ын 176 сая төгрөгийн санхүүжилт олгосон, ажлын явц нь 30 хувьтай гэсэн байна. Энэ тохиолд 100 хувийн санхүүжилтийг олгож болдог уу? Мөн эко нойл хийх тендерийн шалгаруулалтын баримт бичгийг үзэж болох уу? Үзмээр байна.

Т.Чимэддорж: (Сонсгол даргалагч) Худаг усны цахилгааны холбогдолтой асуултыг ХЗА, Түмэнжаргал оролцогчийн асуусан эко нойлтой холбоотой ажлын хэсгийн дүгнэлтийг ИТХ-ын Ажлын албанаас хариулт өгнө байх. Санхүү, тендерийн холбогдох материалтай холбоотой асуудлыг Засаг дарга Б.Ганбат дарга хариулт өгье.

Б.Ганбат: (Засаг дарга) “Эко нойл”-ын хувьд аймгаас 532 сая төгрөг Арвайхээр сумаас 180 сая нийтдээ 700 сая төгрөгийн төсөвтэй. Арвайхээр сумын хувьд санхүүжилтийг 100 олгосон, аймаг 50 хувийг олгосон. Тендерийн холбогдох материалыг ХЗА-ны архитектор Мөнхбаян танилцуулна.

А.Баасанжав: (Отгоннинж ХХК-ны захирал) Сайн байцгаана уу? “Эко нойл”-ын ажлын талаар товч танилцуулга хүргэе. Манай компанийн хувьд 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр 700 сая төгрөгний 260 ширхэг “Эко нойл” хийхээр гэрээ байгуулсан. 2024 оны 11 сарын ажлын гүйцэтгэлээр 100 ширхэг нойлыг хийгээд дууссан. Өвлийн улирал ажил зогсоод одоогоор ажиллаж эхлээд явж байгаа. Арвайхээр сумын санхүүжилтийн 180 сая төгрөг олгосон. 700 сая төгрөгнөөс 350 сая төгрөгийн санхүүжилтийг авч 45 хувийн ажлын гүйцэтгэл явагдаж байна. Ажлын явцад хүндрэлтэй тал нь хад ихтэй газарт удаашралтай байгаа. Зөөлөн хөрстэй айлуудад нойлоо хийгээд дуусгасан. Одоогоор хатуу хөрстэй айлуудад хийгдэх үлдсэн. 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл гэрээгээ сунгасан. Тухайн хугацаандаа гүйцээж хүлээлгэж өгнө. Арвайхээр сумаас тухай бүрд хяналт шалгалтууд явагдсан. Чанарын тал дээр хяналт тавьсан хүмүүс мэдээлэл хүргэнэ байх.

1 ширхэг “Эко нойл”-ыг 3,500,000 төгрөгөөр хийхээр тендер авсан. Нийт 200 нойл 700 сая төгрөг болж байгаа. 200 нойл хийлгэсэн айл өрхөөс 875,000 төгрөгийг Арвайхээр авч байгаа юм байна лээ. Оролцогчдоос асууж, тодруулах зүйл байна уу?

Э.Түмэнжаргал: (8-р багийн иргэн) Тендер нь анх 200 сая төгрөгөөр зарлагдсан юм уу? 180 сая төгрөгөөр зарлагдсан уу? Энэ жилдээ хатуу хөрстэй газруудад нойл хийгдээд дуусах уу? Хадтай дийлэхгүй гээд орхичих юм уу?

А.Баасанжав: (Отгоннинж ХХК-ны захирал) 200 сая төгрөгөөр зарлагдсан. Гэрээний хугацаа нь 08 дугаар сарын 01 хугацаандаа хийнэ. Тендерийн тоон хэмжээндээ 3 дугаар зэргийг хөрс гэж заасан. 3 дугаар зэргийн хөрс нь хадгүй хөрсийг хэлж байгаа. Хадтай хөрс бол 5 дугаар зэргийн хөрс болно. Захиалга өгч байгаа өрхүүд дандаа хадтай. Тийм учраас тендерийнхээ дагуу 3 дугаар зэргийн хөрсийг ухна гэхээр болохгүй болчихоод байна. Хадтай айлын нойлыг аль болохоор ухаад явж байгаа. Техникийн хүчин чадал хүрэхгүй тохиолдолд айлтай нь тохиролцоод молдокор ухуулж хөлсийг нь манайх гаргаж тохиролцож байна.

Э.Түмэнжаргал: (8-р багийн иргэн) Эхнээс тендер зарлахад нь хаана, хаана хэддүгээр хороонд хэдэн нойл ухах вэ гэдгээ тодорхой болгочхоод зарлахгүй. Жишээ нь 4 дүгээр хороо хадтай, 5 дугаар хороо түүддүгээр зэргийн хөрстэй гэх мэтчилэн тендерт оролцож буй компани үнэ хөлсөө бодолцож орохгүй юу гэхэд бөөнд нь 200 ширхэг нойл гээд битүү зарлачихсан. Сүүлд тендер тодорсны дараа хэддүгээр хороонд хэдэн нойл хийх нь тодорхой болсон. Ингэхлээр тухайн компанидаа хүндрэлтэй байгаа. 3 дугаар зэргийн хөрс гээд орсон хойно 5 дугаар зэргийн хөрсийг ухаж байх жишээтэй.

Б.Ганбат: (Засаг дарга) Нэмэлт талбар өгье. Түмэнжаргал оролцогчийн хэлж байгаад баталгаат хугацаа ажил үйлчилгээнд 1 жилээс доошгүй байна гээд хийлгээд явж байгаа. Эдгээр асуудлууд нь хуулийнхаа хүрээнд хийгдэж байгаа. 2-т Орлогч дарга, багийн Засаг дарга нарын ажлын хэсэг байгуулаад “Эко нойл”-ын 3-аас 4 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулсан. Мөн ИТХ-аас ч явсан. Орлогч дарга байхгүй тул дүгнэлтийг танилцуулах боломжгүй байна. Тухайн тендерийг шахуу хугацаанд зарласан.

Ц.Тунгалаг: (ИТХ-ын Ажлын албаны дарга) ИТХ-ын Ажлын албанаас тодруулга хүргэе. 2024 оны Төлөөлөгчдийн 24 дүгээр хуралдаанаар хяналт шалгалтын ажлын дүгнэлт тусгагдаж, тэмдэглэгдсэн. 2024 оны хөрөнгө оруулалтын явц, гүйцэтгэл, чанарт хариуцлагатайгаар ажиллахыг тэмдэглэлд тусгаж, үүрэг өгсөн. Энэхүү асуудал нь өмнөх бүрэн эрхэд хэлэлцэгдсэн асуудал юм. Тухайн асуудалд Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн бодлого зохицуулалтын хороо, Төсөв, эдийн засгийн бодлого зохицуулалтын хороод хэлэлцэж үүрэг өгсний дагуу Засаг дарга хариулт өглөө гэж ойлгож байна. Одоо ажлын хорооны тэмдэглэлийг оролцогчид танилцуулж байна.

Т.Чимэддорж: (Сонсгол даргалагч) П.Баярсайхан оролцогчийн асуусан худаг усны цахилгааны асуултад хариулт өгье.

Б.Ганбат: (Засаг дарга) Арвайхээр суманд ганц цахим худаг биш тогны асуудал бол хүндрэлтэй байгаа. Сумын хэмжээнд нөөцийг сэргээх тал дээр зүүн баруун хэсэгт жижиг аваарын станц барина. Мөн байгууллага бүр аваарын станцыг байрлуулж байна. Манайд 2 тогны эх үүсвэр шийдэгдэх станц байгаа. Энэ мэтчилэн дотооддоо ажиллаад явж байна. Өнгөрсөн оны ИТХ-аар 301 га талбайг тодотгол хийж сумын нутаг дэвсгэр дээр төр, хувийн хэвшлийн түншлэлээр батлуулсан. Энэ нь 100 киловаттын нарны цахилгаан эх үүсвэртэй. Сум 5 хоног тог тасрахад мах нь өмхийрөхгүй, худаг нь тасрахгүй байх асуудлыг ярилцаад явж байна. Өмнөх 3 дахь өдрийн хуралдаанаар Орхон аймгийн Эрдэнэт хот, Дорноговь аймгийн Мандалговь сум, Өвөрхангай аймгийн Арвайхээр сум гэсэн 3 хэсэгт хийгдэхээр яригдаж байгаа. Засгийн газрын шийдвэрээр Хангайн бүсийн хөгжлийн Архангай дахь хуралдаанд Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн энэ төслийг урагшлуулах талаар явж байгаа. Хэрэв энэ асуудал Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тохиолдолд 2025 оны 11 дүгээр сарын 01 гэхэд цахилгааны эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангаад явна. Гэр хорооллын цахим халаалтын асуудал, 2 дугаарт нийгмийн хариуцлагын хүрээнд гэр хорооллын хэсгийн камержуулалт, гэрэлтүүлгийн тог цахилгааныг шийдээд өгөөч гэсэн хүсэлтийг тавьсан. Дараагийн асуудал 3 дахь эх үүсвэрээ Мандал-Овоо, Даланзадгадын чиглэлээс ирж байгаа цахилгааны эх үүсвэр Арвайхээр сумыг дамжин өнгөрөх тал дээр анхаарч ажиллаж байгаа. Ганц Эрдэнэбулган сумын шон унахаар 5 хоног тоггүй болдог асуудал байхгүй болно. Эдгээр 3 цахилгааны эх үүсвэрийг шийдэх гээд ажиллаж байна.

Д.Сосорбурам: (8-р багийн иргэн) ОНХС-ийг зарцуулалтыг иргэдээс санал авч эрэмбэлдэг. Энэ тал дээр иргэдээс санал авахдаа хайнга байна. Хуучин аль аль талдаа ач холбогдол өгч маш идэвхтэй байдаг байсан. Одоо тийм биш болсон байна. ОНХС-ийн хөрөнгийг үр өгөөжтэй зарцуулъя гэвэл иргэдээс санал авах тал дээрээ анхаарахгүй бол болохгүй байна.

Хадтай, хатуу хөрстэй газартаа л “Эко нойл”-той болох хэрэгцээ их байгаа. Хөрс зөөлөн газар бол иргэд өөрсдөө ухчхаж байгаа. Хад ихтэй газартаа хэцүү л юм. Түрүүчийн “Эрчим 2- төсөл бас хад ихтэй гээд мөнгө нэмж төлсөн. Тендер зарлахдаа эдгээр асуудлуудаа сайн тооцдог байх шаардлагатай байх гэсэн саналтай байна. “Эко нойл” шинээр захиалга авах уу?

Б.Баасанжав: (Отгоннинж ХХК-ны захирал) 2024 онд 169 захилга орж ирсэн. 14 айлынх буцаагдаад 100 айлынх хийгдэж дууссан. Үлдсэн 50 айлын нойлыг одоо хийж эхэлж байгаа. Энэ үлдсэн нойлоо хийж дуусаад нэмж 110 айлын захиалга авна.

Д.Сосорбурам: (8-р багийн иргэн) Манай 8 дугаар багт цөөн айлууд хийлгэсэн байна лээ. 15 айл захиалга өгөөд 2, 3 айл л хийлгэсэн. Бас л хад ихтэй газар Хамгийн гол нь хад ихтэй газартаа нойлтой болчихвол агаарын бохирдол багасна даа.

Э.Түмэнжаргал: (8-р багийн иргэн) ИТХ-ын хорооны хяналт шалгалтын дүгнэлттэй танилцлаа. Одоо 100 нойл хийсэн гэж байгаа. Дүгнэлтэд бохир соруулах нүх гаргаагүй гэсэн байна. 100 нойл бүгд бохир соруулах нүхгүй хийгдсэн үү?

Б.Баасанжав: (Отгоннинж ХХК-ны захирал) Тендерийн зурган дээрээ нэг нүхтэй байсан. Зургийн дагуу тагны захиалгаа өгч хийлгэсэн.

Э.Түмэнжаргал: (8-р багийн иргэн) Тендер зарлахдаа зураг хийгдээд зураг төслийн дагуу тендерээ зарладаг баймаар юм. Хийгдсэн 100 нойл соруулах нүх гаргаагүй, суултуураараа соруулна гэсэн үг үү? Эрүүл ахуйн шаардлагыг хангах уу? Нэмэлтээр бохир соруулах нүх хийж болох уу? Үүнээс харахад “Эко нойл”-ын техникийн тодорхойлолт муу гарсан нь харагдаж байна. Ямар ч хяналт алга.

Б.Баасанжав: (Отгоннинж ХХК-ны захирал) Одоогийн хийгдэж байгаа нойлууд бүгд бохир соруулах нүхтэй хийгдэж байгаа. Бохир соруулах нүхгүй хийсэн айлууд солихоор байна гэвэл сольж болно. Зураг төсөл бол нэг нүхтэй хийгдсэн байсан.

Т.Чимэддорж: (Сонсгол даргалагч) Түмэнжаргал оролцогчийн асуусан дээрээс асуухад техникийн тодорхойлолтоо ХЗА-ны архитектор тайлбар өгөх үү? Ямар ч нойл бохир соруулах нүх нь тусдаа байх ёстой шүү дээ. Зураг зүйн хувьд тайлбар өгье.

Т.Мөнхбаян: (ХЗА-ны архитектор) Төсвийн зураг гаргахдаа агааржуулалтын хоолойг гадна шийдсэн. Компанитайгаа ярьж байгаад агааржуулалтын хоолой хийхээр болсон. Тендерийн ажлын хэсгийн дарга нь Б.Гал-Эрдэнэ, нарийн бичгийн дарга нь миний бие байгаа.

Б.Ганбат: (Засаг дарга) Алдаа гаргаснаа хүлээн зөвшөөрч байна. “Отгоннинж” ХХК чадна гэж авчхаад дараа нь иймэрхүү юм ярьж болохгүй ажлын уялдаа холбоотой байх хэрэгтэй. Дараа дараагийн ОНХС-гийн бүтээн байгуулалтад иймэрхүү алдаа гаргаж болохгүй. Манайхан шүүмжийг хүлээн авч байна.

Э.Түмэнжаргал: (8-р багийн иргэн) Тухайн компани чадна гэж авсандаа биш техникийн нөхцөлөөрөө л ажлаа хийнэ. Тэгэхгүй сүүлд нь манайхан сүүлд нь ийм, тийм юм нэмүүлбэгэдэг. Тухайн компани техникийн нөхцөлөөрөө хийсэн гээд суухад яах ч үгүй шүү дээ. Техникийн нөхцөл, зураг төслөө эхнээсээ сайн гаргаж өгөх хэрэгтэй.

Т.Чимэддорж: (Сонсгол даргалагч) Хэдэн зүйл асууж тодруулъя. 4 дүгээр багийн хойно баригдсан ногоон байгууламжийн хашаалах ажлыг “Ховд сафари” компани гүйцэтгэсэн. Гүйцэтгэсэн ажил, чанар, үр дүнгийн талаар мэдээлэл авъя.

Л.Түвшингэрэл: (“Ховд сафари” ХХК-ны менежер) Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнгөрсөн жил манай компани ногоон байгууламжийн хашааг бариад хүлээлгэж өгсөн боловч хогийн цэгтэй ойрхон тул хог маш ихээр ирж ар тал нь тэр чигтээ ханарч унаад өөрийн биеэр ирж 3 өдөр хогийг нь ачиж дахин хүлээлгэн өгсөн. Хог цэвэрлэсний дараа бэхэлгээнүүдийг бүгдийг нь засаж янзалсан. Мөн 1200 ширхэг улиас, бургасыг ЗДТГ-т хүлээлгэж өгсөн. Айл өрхүүдэд бас 1200 чацаргана хүлээлгэж өгөөд өөрсдөө тарьсан. Манай компанийн хувьд олон жил ногоон байгууламжийн үйл ажиллагаагаар явж байгаа. Арвайхээр суманд хийсэн ажлуудаа эргэж нэг хараад дахин засварлаад явж байгаа. Одоо Арвайхээр цогцолборын хаалгыг хүүхдүүд эвдлээд эргэж засварласан. Энэ жил мөн дахин эвдэрсэн байна лээ. Манай байгууллага бол хийсэн ажлаа хянаж, хариуцлагаа хүлээж чаддаг.

Т.Чимэддорж: (Сонсгол даргалагч) Чанарын талаар асуусан. Тухайн хашаа чанарын хувьд асуудалтай харагдаж байна лээ. Комисс нь ямар хүмүүс ажил хүлээлгэж авсан бэ? Багийн дарга нар хэлж байна лээ. хашаа нь хэдэн хог даалгүй унадаг. Гол нь хашаажуулаад тодорхой хэмжээний ногоон байгууламж тарьсан юм байна. Хүлээж авах комиссын хянал гэдэг зүйл байхгүй байна.

Л.Түвшингэрэл: (“Ховд сафари” ХХК-ны менежер) Хашааны чанарын хувьд бид хамгийн сайн төмрөөр барьж хийсэн. Гэвч байгалийн шуурга, хогийн даац зэрэг нь ханаруулж унагаадаг. 3 метр бэхэлгээг дахин хийж төсвөөс давсан ажил хийсэн. Хашааны хувьд хамгийн үнэлгээ сайтай хашааг хийсэн.

Т.Чимэддорж: (Сонсгол даргалагч) Ажил хүлээж авсан комисс ямар хүмүүс байсан бэ?

Б.Ганбат: (Засаг дарга) Хог даахгүй хашаа гэж байхгүй. ОНХС-аар нутаг дэвсгэрт хийж байгаа бүтээн байгуулалтын ажил дээр 2020 оноос хойш бүх багийн дарга нарыг оруулж байгаа. Багийн дарга нар нь өөрсдөө хүлээж байгаад баталгаагүй, чанаргүй гэж үзэж байгаа бол дараагийн асуудалдаа ороод явж болно. Дахин 3 хашаа эвдэрсэн гэсэн гомдол ирсэн. Камержуулалтын систем тавьсан гэсэн. Багийн дарга нартай ХЗА-ны архитектор Т.Мөнхбаян холбож өгөөд асуудлаа яриад яваарай. Хаврын цагт адуу, мал оруулах гээд эвдэлсэн тохиолдол гарсан байна лээ. тэрнээс биш хог даахгүй хашаа гэж байхгүй.

Т.Чимэддорж: (Сонсгол даргалагч) Та хашаа барьснаас хойш очиж үзсэн үү? Очиж нэг хараарай. Хяналтын асуудал буюу комисс хүлээж авахдаа хайнга хангалтгүй байгааг харуулж байна. 2 дугаарт “Мандахтөгс гурван эрдэнэ” ХХК тоглоомын талбай барих ажлын чанар, үр бүтээмжийг танилцуулж мэдээлэл хүргээрэй. Төсөв хөрөнгө нь бага байсан юм болов уу гэж санагдсан.

“Мандахтөгс гурван эрдэнэ” ХХК: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Гэр хорооллын тоглоомын талбайн санхүүжилтийг авсан. Санхүүжилтийн хувьд анхнаасаа тооцож гаргасан. Ер нь бол нь хүйтэнтэй холбоотойгоор ажлууд маань удаашралтай байгаа. Одооноос ажил эхэлсэн энэ сардаа багтаад хүлээлгэж өгнө. Өмнөх суурилуулсан тоглоомууд нэлээн эвдэрсэн. Камержуулалттай холбоотой байна уу, тухайн багийн хүүхдүүд хайхрамжгүй хандаж байгаа нь анзаарагдаж байгаа. Тэр асуудал дээр төлөвлөгдөөгүй төсөв гарч ирж байгаа. Манай байгууллагын зүгээс бол эвдэрсэн тоглоомуудаа засаж янзлаад 100 хувийн гүйцэтгэлтэй хүлээлгэж өгнө. Анхнаасаа гүйцэтгэж чадна гээд тендер авсан учраас гүйцэтгээд дуусгана. Төсөв хүрэхгүй гэсэн асуудал байхгүй.

Т.Чимэддорж: (Сонсгол даргалагч) 2024 оны 12 дугаар сарын 14-ны өдөр хүлээлгэж өгөх гэрээнд заасан хугацаа хэтэрсэн байна. Гэрээнд заасан хугацаанд тухайн ажлыг гүйцэтгэж дуусгана гээд тендерт ордог шүү дээ.

“Мандах төгс гурван эрдэнэ” ХХК: Тухайн үед хийчих хугацаа байсан. Заасан хугацаанд гүйцэтгэе гэхээр улирлаас шалтгаалаад чанаргүй болох эрсдэлтэй байсан. Өвлийн улиралд төмөр хайс будахад хуурах, хүйтэнд бетон зуурмаг хөөх зэрэг асуудлуудтай байсан учир хүсэлт гаргасан. Гэрээнд хугацаанд дуусга гэвэл гүйцэтгэж болох байсан. Хүсэлтийн дагуу ярилцсаны үндсэн дээр 4 сард багтаад хүлээлгэж өг гэсэн чиглэл ирсэн.

Т.Чимэддорж: (Сонсгол даргалагч) Өндөр гэгээн Занабазарын музейг засварлах ажилтай холбоотой асуултад ХЗА-аас хариулах уу? Материал дээр 100 хувийн гүйцэтгэлтэй гэж орж ирсэн. Энэ ажил 100 хувь дуусаагүй байгаа юм байна лээ. Гадна талын эко хавтангууд тавигдаагүй, хяналтын асуудал дутмаг байна. Хөшөөний доод талд 4 тийш харсан цонхоор ус гоождог асуудал одоохондоо дуусаагүй. Цэцэрлэгжилтийн хүмүүс нь өөрсдийн асуудлуудаа шийдмээр байна гээд явсан юм байна лээ. Уул нь захиалагч байгууллага иймэрхүү асуудлууд дээрээ хөөцөлдөөд болж байна уу, болохгүй байна уу гээд хяналтаа тавих ёстой. ХЗА энэ тал дээр илүү ажиллах ёстой юм болов уу гэж бодож байна. Энэ тал дээр тайлбар авъя.

Т.Мөнхбаян: (ХЗА-ын архитектор) ЗДТГ-ын дарга С.Ганчимэг даргаар ахлуулсан ажлын хэсэг, миний бие тогтмол хяналт тавиад явсан. Усан оргилуур дээр 120-ийн нацосс байсныг Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын дарга Д.Мягмар ярьж байгаад 3/80-ын нацосс болгосон. Усан оргилуурыг дулааны улиралд тухайн компани өөрсдөө шалгуулаад хүлээлгэж өгнө. Гадна хэсгийн хөгжим, пультаг угсарсан. Цахилгааны утсаа ил явуулсан учир дулааны улиралдаа цэгцлээд хүлээлгэж өгнө. Бусад ажлууд нь бол жигд дууссан.

Т.Чимэддорж: (Сонсгол даргалагч) Оролцогч нараас асууж тодруулах зүйл байна уу? П.Баярсайхан

П.Баярсайхан: (3-р багийн иргэн) Тоглоомын талбайтай холбоотой асуулт асууя. 8 дугаар багт байрлах тоглоомын талбайг танай компани гүйцэтгэсэн үү? Тухайн тоглоомын талбайн гулгуур стандартад нийцэх үү? Манай хүүхэд тухайн тоглоом дээр тоглоод нүүрээ шалбалсан. Доор нь том ширхэгтэй хайрга асгачихсан байна лээ. 2 дугаарт 2, 7 дугаар багийн тоглоомын талбайн эргэдэг хэсэг нь цөмрөөд уначихсан. Одоо бол гулгуурыг нь аваад тавьчихсан байна лээ. 4 дүгээр багийн тоглоомын талбай мөн адил суурилуулаад удаагүй эвдэрчихсэн. Эрэг боолтыг нь чанартай материалаар хийж болохгүй юу? Тэр тал дээр анхаармаар байна. Танай компанийн гүйцэтгэсэн ажлууд уу?

“Мандах төгс гурван эрдэнэ” ХХК: тухайн дурдсан тоглоомын талбайн ажлыг өөр компани гүйцэтгэсэн. Манай компани 2, 7, 4, 10, 11, дугаар багууд 803-ын гадна тоглоомын талбайн ажлыг гүйцэтгэсэн. Тоглоомын талбай дотроо тоо хэмжээтэй байгаа. 4 дүгээр баг дээр гэхэд элс хайрга болон хайс хийх ажлуудыг хийсэн. Тухайн тоглоомын талбайн ажлыг багцаар нь хийдэггүй. Бид ажил хийхийн өмнө өөр тоглоомын талбайнуудыг очиж үздэг. Захын хажуугийн тоглоомын талбай бол хүүхэд гулгах боломжгүй, хашлагагүй хийгдсэн байна лээ.

Т.Чимэддорж: (Сонсгол даргалагч) Оролцогчдоос өөр асуулттай хүн байна. Асуулт байхгүй гэж ойлголоо. Дарааллын дагуу Арвайхээр сумын 2023 оноос 2024 он дамжсан 2024 оны ОНХС-ийн төсвийн хөндлөнгийн үнэлгээг ИТХ-ын ажлын албанаас танилцуулна.

Ц.Тунгалаг: (ИТХ-ын Ажлын албаны дарга) Дэлхийн банкны төслөөр тогтвортой амьжиргаа төсөл 3 удаа хэрэгжлээ. 3 дахь төсөл нь хэрэгжээд өнгөрсөн онд дууссан. 2024 оноос эхлээд хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс дээр эдгээр ажлууд дүгнэгдэж явдаг гэж ойлгож болно. Хөндлөнгийн үнэлгээг нийтдээ 28 үзүүлэлтээр үнэлдэг. ЗДТГ-аас Төрийн аудитын дүгнэлт, хөндлөнгийн үнэлгээ зэрэг нь албан бичгээр ирээгүй учир бид өөрсдийн шугамаар мэдээллүүдээ танилцуулж байна. 28 үзүүлэлтээс манай дээр эхний 12 үзүүлэлт нь дэлгэрэнгүйгээр ирсэн. Сумын үзүүлэлт нийтдээ 88.80 хувьтай байна. Оролцогчид бас мэдэж байх ёстой. Оролцогчдоос бас ОНХС-ийн төлөвлөлт учир дутагдалтай, сайжруулж шинэчилмээр байна гэсэн санал гарсан. Хөндлөнгийн үнэлгээг товчхон танилцуулъя. Арвайхээр сумын 2023 оноос 2024 он дамжсан 2024 оны ОНХС-ийн төсвийн хөндлөнгийн үнэлгээг танилцуулав. Цаашдын үнэлгээний үзүүлэлтийг дэлгэрэнгүйг манайхаас файлаар авч ЗДТГ ирэх жилийнхээ 2025 оны ажлуудыг илүү үр дүнтэй ажлаасай гэж хүсэж байна. Бид 2023 оны төсвийн хяналтын сонсгол хийж байхад 100 хувийн үзүүлэлттэй улсад 1 дүгээр байранд орж байсан бол 2024 оны төсвийн гүйцэтгэлийн үнэлгээ 90 хувиас буусан үзүүлэлттэй байна. Манай талаас хяналтаа сайжруулъя, ЗДТГ гүйцэтгэх, төлөвлөсөн ажлуудаа хугацаанд нь чанартай хийгээрэй. Хамгийн гол нь иргэдэд төсөл, хөтөлбөрийн үр дүн хүртээмжтэй байх ёстой. Гүйцэтгэж байгаа компаниуд мөн адил чанартай гүйцэтгээрэй. Төлөөлөгчдийн хороодын хяналт шалгалтаар ажлаа сайжруулах тал дээр анхаарах гэсэн дүгнэлтүүд гардаг. Хуралдааны тэмдэглэлээр тусгаж үүрэг чиглэлүүдийг өгөөд явдаг. Өнгөрсөн он сонгуультай онцлог жил байлаа. Одоо бол шинэ бүрэн эрх эхэлсэн. Цаашид илүү эрчимтэй шаардлага тавьж ажиллана. Баярлалаа.

Т.Чимэддорж: (Сонсгол даргалагч)

Ажлын албанаас хэлсэн саналтай санал нийлж байна. Хяналт шалгалт, явцын хяналтаа тавиач ээ. Хяналт сайн байвал тухай гүйцэтгэгч компаниуд техникийн нөхцөлд заасан ажлуудыг дор бүр нь хийгээд явна. Мөн хүлээж авах комисс дээр асуудалтай байна. Дараагаар нь ажлын гүйцэтгэл үр дүнгүй болчихсон нь харагдаж байна. Энэ тал дээр анхаарах шаардлагатай байна.

Ирүүлсэн материалууд албажаагүй байна. Энэ тал дээр ЗДТГ анхааралдаа авах хэрэгтэй. Нийтийн сонсгол гэдэг бол хуулийн дагуу явагддаг. Бүх баримт бичгүүд тамга тэмдэгтэй, албаны дагуу байх ёстой. Хугацаа хэтэрсэн асуудал нэлээдгүй байна. Төсвийн хяналтын сонсгол сарын өмнө товлогдсон ажил шүү дээ. Гэтэл өнөөдөр зарим материалууд ирж байна. Цаашид эдгээр зүйлүүдийг засаж, сайжруулаарай.

ОНХС-ийн хөрөнгөөр хийсэн ажлууд үр ашигт, хүртээмжтэй эсэх нь эргэлзээтэй төсөл хөтөлбөрүүд байгааг ИТХ-ын Ажлын албанд ирсэн бичгээр болон өнөөдрийн ирсэн иргэдийн саналуудыг багтаасныг зориуд хэлмээр байна. Энэ нь миний хувь хүний үзэл бодол биш юм шүү. Төсвийн хяналтын сонсгол хийхтэй холбогдуулаад ИТХ-ын Ажлын албанд бичгээр болон өөрийн биеэр ирж саналуудыг хэлсэн. Нийт сонсголд оролцсон та бүхний санал санаачилгыг ажлын алба тэмдэглэж авсан. Холбогдох шатанд албажуулаад хүргүүлнэ. Төсөв бол өөрөө тооны нийлбэр биш бидний ирэх жилийн төлөвлөгөөний хөгжлийн чиглэл юм аа гэдгийг ойлгох ёстой. Тэр тусмаа ЗДТГ илүү ажил хэрэгч байдлаар хандах хэрэгцээтэй байна.

Энэ удаагийн ОНХС-ийн төсвийн хяналтын сонсголд хүрэлцэн ирж оролцсон та бүхэндээ бүгдэд нь баярлалаа.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт:

1.ОНХС-аар хийгдсэн ажлууд дээр гүйцэтгэх засаглалаас хяналтаа сайжруулж хүлээж авах комисс үр дүнтэй ажил хүлээн авах тал дээр анхаарах

2. Дараагийн сонсголд захиалагч талаас тендер гүйцэтгэгчдийг бүрэн оролцуулах. Төсвийн сонсголд оролцоогүй ач холбогдол өгөхгүй байгаа аж ахуй нэгжүүдтэй дахин хамтарч ажиллах, гэрээ байгуулах эсэх талыг бодолцож үзэх

3. Ажил хариуцаж байгаа мэргэжилтэн ажил хэрэгч ажиллах, мэдээлэлтэй, мэдлэгтэй байх.

4. Материал ирүүлэхдээ албажуулан, заасан хугацаанд ирүүлэх

5. ОНХС-ын эрэмбийн асуудалд анхаарах, орон нутагт хэрэгцээ шаардлагатай төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд анхаарч алдааг засаж, ажлаа сайжруулан хууль тогтоомжийн дагуу ажиллах чиглэл өгөв.

Нийтийн сонсгол 11 цаг 40 минутад дуусав.

ХЯНАСАН:
 СОНСГОЛ ДАРГАЛАГЧ Т.ЧИМЭДДОРЖ
 ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨДСӨН:
 ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН
 АЖИЛТАН Б.ЦОГЗОЛМАА